

## АГУУЛГА

БҮЛЭГ 1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	2
1.1 Төслийн нэр.....	2
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл .....	2
1.3 Төслийн хүчин чадал .....	2
1.4 Уурхайн дэд бүтэц .....	2
1.4 Уурхайн ажиллах горим.....	3
1.5 Усан хангамж .....	4
1.6 Цахилгаан хангамж.....	4
БҮЛЭГ 2.ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	6
2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил ,физик газар зүйн нөхцөл .....	6
2.2 Физик газарзүй .....	6
2.3 Ургамал, амьтан .....	7
2.4 Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч:.....	9
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙН .....	11
3.1 Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	11
3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	11
3.3 Гадаргын болон гүний усан үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	11
3.4 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл үргэжлэх хугацаа ,эрчим.....	12
БҮЛЭГ 4. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	17
БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	19
БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	20
БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21

БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	22
БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	23
БҮЛЭГ 12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	25
БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	26

### **Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт № 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл .....	2
Хүснэгт № 2 Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө .....	2
Хүснэгт № 3 Барилга, байгууламж, хийц бүтэц .....	3
Хүснэгт № 4 Ил уурхайн ажлын горим .....	3
Хүснэгт № 5 Магадлан жагсаах арга .....	12
Хүснэгт № 6 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал.....	16
Хүснэгт № 7 Сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө .....	17
Хүснэгт № 8 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний менежментийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт № 9 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө .....	22
Хүснэгт № 10 Орчны хяналт шинжилгээний менежментийн төлөвлөгөө .....	23
Хүснэгт № 11 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	25
Хүснэгт № 12 Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө .....	26
Хүснэгт № 13 Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	27

### **Зургийн жагсаалт**

Зураг № 1 МР-68С-60 маркийн дизель генератор.....	5
Зураг № 2 Төслийн талбайн байршил.....	6
Зураг № 3 Ургамлан бүрхэвчийн хэв шинж .....	9
Зураг № 4 Хөрсний хэв шинжийн тархалтын зураг .....	10

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн нэр

“Шарангатай” хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

### 1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Хүснэгт № 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл


Төсөл хэрэгжүүлэгч	“Терра Виста” ХХК
Төсөл	“Шарангатай” хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-022056
Улсын бүртгэлийн дугаар	9011554003
Регистрийн дугаар	5968216
Хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, Төгөл хус 12-1 тоот
И-Мейл	99009348

### 1.3 Төслийн хүчин чадал

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөг захиалагч компанийн техникийн даалгаврын дагуу жилд 40.0 мян.тн -ын хүчин чадалтайгаар 5 жил ашиглахаар төлөвлөлөө.

Хүснэгт № 2 Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Ашиглалтын жилүүд	Хүдрийн нөөц		Дундаж агуулга	Эрдсийн нөөц	Хөрс хуулалтын хэмжээ	Хөрс хуулалтын коэффициент
	мян.м <sup>3</sup>	мян.тн	%	мян.тн	мян.м <sup>3</sup>	м <sup>3</sup> /тн
1-р жил	11.5	30.0	44.5	13.4	90.2	3.0
2-р жил	15.4	40.0	43.1	17.2	92.1	2.3
3-р жил	15.4	40.0	42.9	17.2	85.5	2.1
4-р жил	15.4	40.0	42.8	17.1	72.1	1.8
5-р жил	12.5	32.6	37.8	12.3	51.2	1.6
Нийт	70.2	182.6	42.3	77.2	391.1	2.1



### 1.4 Уурхайн дэд бүтэц

Уурхайн барилга байгууламж

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ШАРАНГАТАЙ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхай, үйлдвэрийн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр, агуулах-засварын байр багтах бөгөөд эдгээр нь уурхайн зүүн талд байрлана.

Хүснэгт № 3 Барилга, байгууламж, хийц бүтэц

№	Нэр	Хийц, бүрдэл	Тоо, ш
1	Сэлбэг, материалын агуулах, 30м2	Контейнер	2
2	Харуул хамгаалалтын байр, 5м2	Сэндвич	2
3	Засварын цех, 200м2	Сэндвич	1
4	Оффис, 80м2	Сэндвич	1
5	Амрах байр, 200м2	Сэндвич	1
6	Гал тогоо, 100м2	Сэндвич	1
7	Душ, 20м2	Контейнер	1
8	Түлшний агуулах, 60м3	ёмкость	1
9	Тэсрэх материалын агуулах, 5тн	Контейнер	1
	Дүн		11

Түлш хадгалах зориулалтаар 60 тонны багтаамжтай ган сав 1 ширхэг, масло болон бусад тос материалыг зориулалтын савтай нь тус тус хадгална. ШТМ-ын гал аюулгүй байдлын шаардлага, норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.

#### 1.4 Уурхайн ажиллах горим

Уулын ажил нь жилд 8 сар явагдана. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 1 ээлжээр 10 цагаар явагдана.

Туслах ажлууд болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг зэрэг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ. Уурхайн ажиллах горимыг захиалагч байгууллагын техникийн даалгавар, уурхайн жилийн хүчин чадалтай нь уялдуулан ажиллахаар байна.

Хүснэгт № 4 Ил уурхайн ажлын горим

Үзүүлэлт	Х.нэгж	Хоног
Календарь хоног	хоног	180
Жилд ажиллах сар	сар	6
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10
Ээлжийн тоо	ээлж	1
Баяр ёслолын хоног	хоног	10
Цаг агаарын саатал	хоног	8
Бэлтгэл ажлын хоног	хоног	2
Жилд ажиллах хугацаа	хоног	160

### **1.5 Усан хангамж**

MV-022056 тусгай зөвшөөрлийн талбай нь геологи-гидрогеологийн хувьд харьцангуй сайн судлагдсан, ордыг ашиглах үед гадаргын болоод газрын доорх уснаас үүсэх уул-техникийн хүндрэл үндсэндээ байхгүй.

Ордыг ил аргаар ашиглах үед технологийн усны хэрэгцээ гарахгүй бөгөөд уурхайн зам услахад л багахан хэмжээний ус шаардлагатай.

Хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглахад уурхайн мөргөцөг нь газрын гадаргуугаас доош 50м-т байхад уурхайд газрын доорх ус маш бага хэмжээтэйгээр орж ирэх ба энэ нь гол төлөв агаарын хур тунадасны чөлөөт нэвчилтээс үүссэн ан цавын, ан цав-давхаргын ус байна.

Харин унд ахуйн зориулалттай усыг өрөмдмөл худгийн усаар хангах боломжтой ба энэхүү бүс нутгийн газрын доорх ус нь ундны усны улсын стандартад тохирдоггүй тул усыг шүүж, зөөлрүүлж хэрэглэнэ.

Усзүйн хувьд Төв азийн гадагш урсацгүй ай савд Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газарт хамаарна. Тус сав газарт 8 аймгийн 58 сумын нутаг дэвсгэр хамаарч, 180404.2 км<sup>2</sup> талбайг эзлэн оршдог. Дундговь аймгийн 69.2 хувьд нь энэхүү сав газарт хамаардаг байна.

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрыг дотор нь дэд сав газруудад ангилан авч үздэг бөгөөд MV-022056 хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Өлзийтийн газрын доорх усны дэд сав газарт хамаарна.

“Терра виста” ХХК нь Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших сумын хэрэгцээний гүний худгаас унд ахуй, зам талбайн усалгаа болон биологийн нөхөн сэргээлтийн усалгааг хангана.

Төсөл хэрэгжүүлэгч “Терра виста” ХХК нь унд ахуйн, зам талбайн усалгаа, нөхөн сэргээлтийн усны хэрэглээг худгаас хангахаар өлөвлөсөн байна.

Ордыг ашиглах үед усны дараах үндсэн хэрэглэгч байна. Үүнд:

- Унд ахуйн ус
- Зам талбайн усалгаа
- Биологийн нөхөн сэргээлт

### **1.6 Цахилгаан хангамж**

Уурхайн нийт цахилгааны хэрэглээг 50 кВт болон 160 кВт-ийн чадалтай дизель үүсгэвэрээр хангахаар төлөвлөсөн. Уурхайд бутлан ялгах хэсэг, ил уурхайн гэрэлтүүлэг, хотхоны гэсэн цахилгаан хэрэглэгч байна.




Зураг № 1 MP-68C-60 маркийн дизель генератор

## БҮЛЭГ 2.ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил ,физик газар зүйн нөхцөл

MV-022056 тусгай зөвшөөрөл бүхий “Шарангатай” хайлуур жоншны орд нь засаг захиргааны хувьд Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт харьяалагдах ба Улаанбаатар хотоос урагш хатуу хучилттай замаар 356км-т Дундговь аймгийн Хулд сум хүрэх ба зүүн тийш 36км-т байрлана.

- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-022056
- Талбайн нийт хэмжээ: 63.22 гектар
- Номенклатур планшетын дугаар: L-48-105



Зураг № 2 Төслийн талбайн байршил

### 2.2 Физик газарзүй

Уг талбай нь Дундговь аймгийн төвөөс урагш, Өлзийт сумын хойд хэсгийг хамран хээр ба говийн их мужийн шилжилтийн заагаар орших бөгөөд цав толгодлог, ухаа гүвээт гэсэн 2 төрлийн рельеф зонхилдог.

Цав толгодлог рельефийн үнэмлэхүй өндөр нь баруунаас зүүн урагшлах тутам аажим намсах ба ихэвчлэн бөмбөгөрдүү оройтой налуу хажуутай байдаг. Боржин болон дэл судлын чулуулаг тархсан газар янз бүрийн хэлбэртэй цохионууд ажиглагдана.

Мөлгөрдүү ухаа гүвээт талархаг рельеф нь цэрд, юрагийн хурдас тархсан нутгуудаар голлон байрлана. Харьцангуй өндөр нь 10-30м байдаг. Ийм төрлийн рельеф нь гуу жалгаар харьцангуй бага хэрчигдсэн. Маш налуу хажуутай толигор оройтой бөгөөд, цав толгодлог рельефтэй хяр хэцүүдтэй ихэвчлэн налуу хажуугаар хааяа мөргөцгөөр тусгаарлагдана. Чулуулгийн гарш, илэрц нь толгодын хажуу хормой, хааяа оройн хэсгээр тохиолдоно.

### 2.3 Ургамал, амьтан

Ургамлын бүрхэвчийн хувьд тыал хээрийн бүсийн өвслөг ургамал зонхилох ба хайлаас, яшил, сухай, заг зэрэг модлог ургамал цөөн тоотой ургах бөгөөд нутгийн ихэнхи хэсгээр алтан болон улаан харгана, хотир, бүйлс, товцог, дэрс зэрэг бутлаг ургамал элбэг дайралдахаас гадна багалуур, бударгана, хуйраг, шар болон бор шаваг, агь, гашуун, хазаар, ерхөг, хялгана зэрэг малын гол тэжээлийн ургамал тархмал ургадаг. Мөн шар мод, цулхир, гоёо, хармаг, хүмүүл, таана, тэмээн хөх зэрэг хүнсний төрлийн ургамал, загсгал, зээрийн ундаа, цулбуур цахилдаг, чихэр өвс юм дүүжин, халгай, шарилж зэрэг эмийн ургамалууд элбэг ургадаг болно. Амьтны аймгийн хувьд араатан амьтдаас чоно, үнэг, хярс, мануул, мэрэгчдээс зурам, алга даага, олон зүйл хээрийн хулгана, туулай, туурайтнаас цагаан зээр, хар сүүлт зээр, жигүүртэн шувуудаас бүргэд, элээ, тогоруу, тагтаа, ятуу, бор шувуу, ууль, шар шувуу амьдарна. Тогоруу, галуу, цахлай зэрэг усны шувууд хавар-зуны цагт жижиг нуур цөөрмүүдээр дамжин өнгөрөөд намрын цагт өмнө зүгт буцдаг. Шавьжны аймгаас төрөл бүрийн цох хорхой, царцаа, голио, хилэнцэт хорхой, төрөл бүрийн аалз, эрвээхэй, хэвлээр явагчдын аймгаас хортой хоргүй могой, хонин болон могойн гүрвүүл зэрэг амьтан элбэгтэй юм. Мөн хайгуулын талбайн районд сүүлийн жилүүдэд нэн ховор ан амьтан болох аргаль нутагшин амьдарах болсон байна.

**Монгол өвс-харганат, монгол өвс –шаваг-боролзойт (63--60 /У-VI-1-6; У-VI-1-3)** хээрийн бүлгэмдэлийн (1 –р цэг) 100м<sup>2</sup>-д Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes songorica* (Roshev.) Ohwi.), Таана буюу багалгар сонгино (*Allium polyrhizum* Turcz. ex Rgl.), Алтан харгана (*Caragana leucophloea* Pojark.) Lam.), Нарийн навчит харгана (*Caragana stenophylla* Pojark.), Төлөгчдүү боролз (*Ajania achilleoides* (Turcz.) Poljak.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.) зонхилж, буурцагтанаас Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), цөөн настанаас Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Баг хуш-хамхаг (*Halogeton glomeratus* (M.B.)C.A.Mey.), Бага хургалж (*Eragrostis minor* Host) болон олон настанаас Нарийн цахилдаг (*Iris tenuifolia* Pall.), Бууралдуу янгиц (*Ptilotrichum canescens* C.A. Mey.) зэрэг, нийт 3 овог, 13 төрөл, 14 зүйл ургамал ургасан, 1м<sup>2</sup>-д 3 -5 орчим




зүйл тааралдаж байв. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 37.0%, нийт бүрхэцэд хайрга чулуу 13.6%, халцгай газар 49.4% байна.

**Монгол өвс -улаан бударгана-бударганат (150/ЦХ-I-1-9)** говийн цөлийн хэрийн бүлгэмдэлд (2 –р цэг) үетэнээс Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes songorica* (Roshev.) Ohwi.), Зүүнгарын улаан бударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.), Бор бударгана (*Salsola passerina* Bge.), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* C.A.Mey.) зонхилж, алаг өвснөөс Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl), талхлагдлын заагуур ургамлаас Шүлхий шарилж (*Artemisia pectinata* Pall.), сонгинолог ургамлаас Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex Rgl.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.) зэрэг нийт 100м<sup>2</sup> талбайд 6 овог, 8 төрөл, 9 зүйл ургамал ургасан, 1м<sup>2</sup>–д 4-6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 34.8%, нийт гадаргын бүрхэцэд хайрга чулуу 12.0%, халцгай газар 53.2% байна.

**Монгол өвс-таана -бударганат (148/ ЦХ-I-1-7)** цөлөрхөг хээрийн бүлгэмдэлд (3 –р цэг) Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), сонгинолог ургамлаас ургамлаас Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex Rgl.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), болон Зүүнгарын улаан бударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.), Бор бударгана (*Salsola passerina* Bge.) зонхилж, үетэнээс Зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes songorica* (Roshev.) Ohwi.), Нарийн цагаан суль (*Elymus angustus* Trin.), улалжаас Утсан навчит улалж (*Carex stenophylloides* V.Krecz.), алаг өвснөөс Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl), Хуурамч дэрэвгэр хависгана (*Scorzonera pseudodivariata* Lipsch.) талхлагдлын заагуур ургамлаас Сибирь шорной (*Atriplex sibirica* L.), Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.) Ktze.), Шүлхий шарилж (*Artemisia pectinata* Pall.), Говийн хэрээннүд (*Asparagus gobicus* Ivanova.ex Grub.), заримдаг сөөгөнцөр Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* C.A.Mey.), Гоолиг бадаргана (*Kalidium gracile* Fenzl.), Гурвалсан боролз (*Ajania trifida* (Turcz.) Tzvel.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.) зэрэг нийт 100м<sup>2</sup> талбайд 8 овог, 16 төрөл, 18 зүйл ургамал ургасан, 1м<sup>2</sup>–д 4-6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 34.0%, нийт гадаргын бүрхэцэд хайрга чулуу 6.6%, халцгай газар 61.4% байна.

**Монгол өвс –бударганат (151/Ц-I-1-8)** бүлгэмдэлд (4 –р цэг) Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Зүүнгарын улаан бударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.), Бор бударгана (*Salsola passerina* Bge.) зонхилж, үетэнээс Нарийн цагаан суль (*Elymus angustus* Trin.), сонгиноос Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex Rgl.) алаг өвснөөс Өтлүүн багдай (*Dontostemon senilis* Maxim.), Хуурамч дэрэвгэр хависгана


(*Scorzonera pseudodivaricata* Lipsch.), Монгол хависгана (*Scorzonera mongolica* Maxim.), буурцагтанаас Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.), талхлагдлын заагуур ургамлаас Өргөст бударганат (*Salsola pestifera* Nels.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.), Шүлхий шарилж (*Artemisia pectinata* Pall.), сонгинолог ба үндэслэг ишт ургамлаас ургамлаас Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), Говийн хэрээннүд (*Asparagus gobicus* Ivanova.ex Grub.), заримдаг сөөгөнцөрөөс Сибирь хармаг (*Nitraria sibirica* Pall.), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* C.A.Mey.), Ямаан ангалзуур (*Lagochilus ilicifolius* Bge.) зэрэг нийт 100м<sup>2</sup> талбайд 11 овог, 13 төрөл, 16 зүйл ургамал ургасан, 1м<sup>2</sup>-д 4-6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 36.2%, нийт гадаргын бүрхэцэд хайрга чулуу 3.2%, халцгай газар 60.6% байна.



Зураг № 3 Ургамлан бүрхэвчийн хэв шинж

## 2.4 Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч:

Төсөл хэрэгжих талбай нь хөрс газарзүйн мужлалаар Говийн их мужийн заримдаг цөлийн бор хөрсний дэд бүсийн хулд өндөршилийн тойрогт хамаарна.



Зураг № 4 Хөрсний хэв шинжийн тархалтын зураг

### **БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙН**

#### **3.1 Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Агаарын чанарт нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд:

Уурхайн тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилт:

- Хүдрийн овоолгын уусгалт
- Хүдэр овоолох талбай
- Уурхайн гадаад тээвэрлэлт
- Техник тоног төхөөрөмжийн дуу чимээ

Хөрс хуулах, түрэх, тээвэрлэх зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө. Үүнээс гадна барилга угсралтын үйл ажиллагаа болон тээврийн хөдөлгөөнтэй холбоотойгоор агаарын бохирдол үүсч болзошгүй.

#### **3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Уурхайн олборлолтын болон бусад төрлийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийн эх үүсвэр нь:

Ордын ашиглалтын хугацаанд 6.2 га эвдрэлд орох бөгөөд ордын барилга байгууламж барих бүтээн байгуулалтын үед хөрсөн бүрхэвч ихээр талхлагдана. Цаашлаад үйл ажиллагааны явцад засвар үйлчилгээ, ШТМ агуулах, ахуйн хог хаягдал зэргээс хөрс бага зэрэг бохирдох.

#### **3.3 Гадаргын болон гүний усан үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд:

Төслийн үйл ажиллагааны явцад дараах эх үүсвэрүүдээс гадаргын болон газар доорх усны нөөц, чанарт нөлөөлөл бий болж болзошгүй. Үүнд:

- Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөц хомсдох
- Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны нөөц хомсдох
- Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах
- Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч хальхаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг борхирдуулах

- Техник, тоног төхөөрөмжийн шатах тослох материал алдагдаж хөрсийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах
- Уурхайн байгууламж, хоосон овоолго, хаягдлын сан, техник хэрэгслийн байршуулалт зэргээр газрын гадаргыг өөрчилж улмаар байгалийн хур тунадас унаж урсац бүрдэх, хөрсний чийг, газрын доорх усыг сэлбэх нөхцөлийг доройтуулах магадлалтай.

### 3.4 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл үргэлжлэх хугацаа ,эрчим

**Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим:** Уг төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, судалгаа хийсэн мэргэжлийн судлаачдын дүгнэлтүүдийг үндэслэн тогтоов. Байгаль орчны төлөв байдалд гарч болзошгүй нөлөөлөл, болзошгүй ослын үнэлгээг магадлан жагсаах аргаар тодорхойлов.

**Магадлан жагсаах /checklist/ аргаар тооцсон нөлөөллийн үнэлгээ:** Үнэлгээ хийгдэж буй төслийн үйл ажиллагаа байгаль орчны төлөв байдал, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг тодруулахын тулд магадлан жагсаах (checklist) аргыг ашиглав. Энэ арга нь нөлөөллийг байна (х), байхгүй (хоосон) гэсэн хэлбэрээр тодорхойлж шууд, шууд бус шинжтэй, удаан, богино хугацаагаар буцалтгүй болон буцаж нөлөөлөх, хүчтэй, дунд болон бага зэрэг эрчимтэй байх зэрэг үзүүлэлтүүдээр авч үзсэн болно.

Төслийн байгаль орчинд сөргөөр нөлөөлөх эх үүсвэрүүдэд дараах хүчин зүйлс орж байна.

Үүнд:

- ✚ Хөрс хуулалт
- ✚ Уурхайн олборлох, ачих, буулгах, тээвэрлэх үйл явц.

Төсөл хэрэгжсэнээр тухайн нутгийн байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг хүснэгтэд харуулав.

Хүснэгт № 5 Магадлан жагсаах арга

№	Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөлөл			Хугацаа		Давтамж		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө	Богино хугацааны	Удаан хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй
<b>Байгалийн экосистемийн өөрчлөлт</b>											
1	Газрын доорх урсацын өөрчлөлт										


ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ШАРАНГАТАЙ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2	Гадаргын усны чанарын өөрчлөлт		x			x	x			x	
3	Ургамлан бүлгэмдлийн бүтцийн өөрчлөлт	x				x		x			x
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x			x
5	Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x		x	
6	Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт	x				x		x		x	
7	Уур амьсгалын өөрчлөлт		x			x		x	x		
<b>Байгалийн нөөцийн ашиглалт</b>											
8	Газрын доорх нөөц баялаг	x				x		x		x	
9	Бэлчээрийн байдал	x				x		x		x	
10	Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x		x	
<b>Байгаль орчны чанарын өөрчлөлт</b>											
11	Агаарын бохирдол	x			x		x			x	
12	Ундны усны нөөц хомсдох		x			x		x	x		
13	Хөрсний бохирдол		x			x	x			x	
14	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	x			x			x		x	
<b>Нийгэмд үзүүлэх нөлөөлөл</b>											
15	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөл	x				x		x	x		
16	Хүн амын орлого өөрчлөгдөн нэмэгдэх		x			x		x	x		
17	Хүн амын тоо өөрчлөгдөх		x			x		x	x		
<b>Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентлогийн олдвор</b>											
18	Байгалийн өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x			x
19	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x	
20	Тусгай хамгаалалттай ба цогцолборт газарт нөлөөлөл										
21	Түүх сёлын дурсгалт зүйлд нөлөөлөл										
22	Археологи, палентлогийн олдворт нөлөөлөл										
<b>Эдийн засаг, байгаль орчин</b>											
23	Орон нутгийн орлого нэмэгдэх		x			x		x		x	
24	Ажлын байр нэмэгдэх	x				x		x		x	
25	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		x		x			x	x		
<b>Бусад нөлөөлөл</b>											
26	Шороон зам, уурхайн машин механизмын хөдөлгөөн, тээвэрлэлтээс хөрс эвдрэх	x				x	x				x

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ШАРАНГАТАЙ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

27	Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба усыг бохирдуулах	х			х	х			х		
28	Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	х		х		х			х		
29	Хүчтэй салхи, уруйн үер	х		х		х			х		
<b>Дүн</b>		18	8		5	20	7	18	5	15	6

Дээрх хүснэгтээс харахад тус төслийн үйл ажиллагааны явцаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой нэг нь нөгөөдөө шууд буюу дам байдлаар нөлөөлөх нь харагдаж байна.



Тус ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд үзүүлэх ба 7.1% нь “бага”, 45.2% нь “дунд”, 42.8% нь “их”, 4.8% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Нөлөөлөлд өртөж буй байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдээс газрын гадарга, хэвлий нь нөлөөлөлд илүүтэйгээр өртөхөөр байна.

#### **БҮЛЭГ 4. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг дэвсгэрт “Терра виста” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Шарангатай” хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар олборлох” төслийн үнэлгээний ажлын явцад үйл ажиллагааны товч танилцуулга, эрхлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны тодорхойлолт болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн суурь төлөв байдлыг тодруулж үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд тэдгээрийн цар хүрээг тооцон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээний зөвлөмжийн хүрээнд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсрууллаа.

Төслийн хэрэгжилтийн явцад барилга байгууламжийн бүтээн байгуулалт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас хамгийн ихээр эвдрэлд орж сөрөг нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн нь хөрсөн бүрхэвч юм. Сөрөг нөлөөллийн цар хүрээ багаас дунд зэрэг ба урьдчилан сэргийлэх болон бүтээн байгуулалтын дараа болон олборлолт дууссан хэсэгт нөхөн сэргээх талаар төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх тохиолдолд нөлөөллийн эрчим эрс буурах боломжтой.

Төслийн ерөнхий үнэлгээний нөхцөлд заагдсаны дагуу байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар жил бүрийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү тайлангийн 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) үндэслэн боловсруулж БОАЖЯ-д ирүүлэн батлуулах ба батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг холбогдох газруудад хүргүүлж байх шаардлагатай. Үүнээс гадна тус Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ), түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь”-ийн дагуу оролцогч сонирхогч талуудыг холбогдох мэдээллээр ханган ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.



ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ШАРАНГАТАЙ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ  
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 6 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

БОМТ-ний нийт зардал	
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний менежментийн төлөвлөгөө	1.250.0
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	3.240.0
Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	-
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1.200.0
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	500.0
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1.050.0
Удирдлага зрхион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	1.500.0
Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
Нийт	8.740.0

**БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт № 7 Сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
						2024 он	
Уурхайн олборлолт болон тээврийн Хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: - Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил, - Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	Ү.а-ны турш		-	650.0	Салхи ихтэй үед 7 хоногт 3 удаа, тогтуун үед 2 удаа	БОС-ын 1995 оны 153 тоот тушаал
	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, сургалт сурталчилгаа явуулах	Ү.а-ны турш		-	ҮА-ны зардалд	2024	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
	Хүнд машин механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах, үзлэг шалгалтыг хийх засвар үйлчилгээг тогтмол хийх	Ү.а-ны турш		-	ҮА-ны зардалд	2024	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
<b>Хөрсөн бүрхэвч</b>							

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ШАРАНГАТАЙ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ  
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх.	Асгаралтын үе хэрэглэх багаж хэрэгслээр хангаж ажиллах	Үйл ажиллагааны турш		-	600.0	2024	
	Төслийн эдэлбэр газраас бусад талбайн ургамлыг хамгаалах зорилгоор ажилчид болон машин техникийн хөдөлгөөнийг тогтсон маршрутын дагуу явуулах, авто зогсоолыг тэмдэгжүүлэх	Үйл ажиллагааны турш		-	Ү.а-ны зардлаар	2024	
	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хураах	Үйл ажиллагааны турш		-	Ү.а-ны зардлаар	2024	
<b>Усан орчин</b>							
Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд	Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх	Төслийн явцад		-	Ү.а-ны зардлаар	2024	
	Ахуйн гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл худалдаж авах (галын хор, гал унтраагч, ус цацагч гэх мэт)	Галын аюулгүй ажиллагааны хүрээнд		-	Осол эрсдэлийн менежментийн зардалд	2024	
	Ажилчдын гал тогоо, амрах байр, хог хаягдлын цэг, 00-ийн	Ажилчдын байрны хүрээнд		-	Орчны хяналт шинжилгэ	Сард 1 удаа	

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ШАРАНГАТАЙ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ  
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

сөргөөр нөлөөлж болзошгүй.	ариутгал халдваргүйжүүлэлт				эний зардалд		
Нийт зардал		1250.0 мян.төг					

**БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төсөл хэрэгжүүлэгч “Терра виста” ХХК нь ашигт малтмал эрэл-хайгуулын шатнаас эхлэн орон нутгийн удирдлагуудтай уулзаж сургуулийн тохижилт, хашаа хайс будах, өвөлжилтийн бэлтгэл ажил зэрэг ажлуудыг сумын иргэдтэй хамтран ажиллаж ирсэн билээ. Тус ордыг ил уурхайн аргаар ашиглах бөгөөд нөхөн сэргээлтийн ажлын сум орон нутгаас санал авсан дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээгээр шийднэ.

**БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт № 8 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний менежментийн төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг	Баримтлах эрхзүйнбаримт бичиг,стандарт аргачлал
					2024	
<b>Дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө</b>						
1	Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх		Ү.а-ны эхэнд	2024 он	ҮА-ний зардалд (ДХ ажлын зардал)	MNS 5914:2015, MNS 4597:2013
2	Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	талбайд 100 ширхэг мод тарих			ҮА-ний зардалд (ДХ ажлын зардал)	
Нийт дүн мян.төг						3.240.0

### **БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл аж иллагаа хийгдэхгүй тул 2024 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

### **БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Терра виста” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна. Үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулна.

**БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт № 9 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх гарын авлагатай болох	Төсөл хэрэгжүүлэгчийн удирдах ажилтан албан хаагчдад үүрэг даалгавар өгөх	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2024 онд	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай байх	Төслийн бүхий л үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2024 онд	
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох	Ус, элс, шороо, хүрз цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт	-	100.0	200.0	2024 онд	
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх		-				
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах		-				
Эрүүл мэнд	Ажилчдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах		1	1.000.0		2024 онд	
<b>Нийт зардал (мян.төг)</b>				<b>1.200.0</b>			

**БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

Хүснэгт № 10 Орчны хяналт шинжилгээний менежментийн төлөвлөгөө

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж 2024 он	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
<b>Хөрсний бохирдол</b>							
Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 2 цэг сонгох /Уурхайн кемп орчим, уурхайн ухаш/	Жил тутамд	Жилд 1 удаа	15.0	2 цэгт х 2 дээж х жилд 1 удаа х 1 жил /15.0/ НИЙТ 60,0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж -15.0 төг	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс.
Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	2 цэгт /Засварын цех, ШТС/	Жил тутамд	Жилд 1 удаа	20.0	2 цэгт х 2 дээж х жилд 1 удаа х 1 жил х 20,0 Нийт 160,0 хүнд металлын шинжилгээ 1 дээж- 20.0 төг/	
<b>Усны хяналт шинжилгээ</b>							
Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	2024 он	Жилд 1 удаа		40.0*2 удаа х 1 жил НИЙТ 80.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон
Усны түвшин усны ундарга нөөц	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх	Гүний худгийн ус, Гол	2024 он				



ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ШАРАНГАТАЙ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ  
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	усны горим өөрчлөгдөх						тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 2024 оны зардлын дүн						500.0	

**БҮЛЭГ 12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт № 11 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт, стандарт
							2024 он	
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүй гэс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгаж байх	Үйл ажиллагааны турш	-	-	-		+	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заатлууд  Хог хаягдлын тухай хуулийн 14-рзүйл
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, аль болох олон газарт байрлуулах	Үйл ажиллагааны турш	-	-	-	350.0	+	
	Хаягдал тосыг хуримтлуулах сав байрлуулах	Үйл ажиллагааны турш	-	-	-	200.0	+	
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан цуглуулах цэгийг хашаажуулах, тэмдэг тэмдэглэгээ тавих	Үйл ажиллагааны турш	-	-	-	300.0	+	
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлыг тусгай бодис хэрэглэн задлах	Үйл ажиллагааны турш	-	-	-	200.0	+	
Нийт						1.050.0 мян.төг		

**БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт № 12 Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Зардал мян.төг	Хугацаа 2024 он
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		2024 он
2	Байгаль орчныг хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар жилд 2 удаа сургалт, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Уурхайн хэмжээнд	Осол эрсдэлийн менежментийн зардалд		2024 он
3	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ-т хүргэн өгч байх	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүрийн 12 сард
4	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх	Уурхайн хэмжээнд		1.000.000	
5	Байгаль хамгаалахад сум багийн холбогдох ажилтнуудын оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	Уурхайн хэмжээнд	Удирдлагын түвшинд		2024 он
6	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	Уурхайн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр		2024 он
7	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах сургалт зохион байгуулах, галын аюулгүй ажиллагааны талаар дүүргийн ГТТХХэлтэстэй хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзүүлэх сургууль хийх	Уурхайн хэмжээнд	Ослын сургалттай хамтран хэрэгжүүлэх		3-р улирал
8	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Улирал бүр
9	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүр
<b>Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал</b>				1.500.0	

**БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН  
БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт № 13 Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлэгээр санал авах	Зохион байгуулах газар
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Дундговь аймгийн Өлзийт сумын иргэдэд танилцуулж хэлэлцүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумдын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	БОМТ-ний хэрэгжилтийн явцад орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон оршин суугчдад танилцуулна.	Сумын засаг захиргааны удирдлага болон байгаль орчны байгууллагын санал, шүүмжийг хүлээн авч шийдвэрлэх	Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг захиргааны байранд
	Нутгийн оршин суугчдад БОМТ-ний биелэлтийг тайлагнах	БОМТ-ний биелэлт		Оршин суугчдын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	
Нийт зардал		-			